



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2015 оны 02 сарын 27 өдөр

Дугаар 78

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах  
тухай


Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 129 дүгээр тогтоолоор батлагдсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 3 дугаар зүйлийн 3.1.9 дэх заалт, Эрүүл мэнд, спортын яамны удирдлагын зөвлөлийн 2015 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, аюулгүй болгох, устгах ажил үйлчилгээ, халдваргүйжүүлэлтийн үйл ажиллагаанд дотоодын хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, удирдамжийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

2. Дотоодын хяналт, шинжилгээ, үнэлгээг 2015 оны 1 дүгээр улиралд багтаан хийж дуусган, Эрүүл мэнд, спортын яамны Удирдлагын зөвлөлийн хуралд танилцуулахыг Хяналт-Шинжилгээ дотоод аудитын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Э.Оюунсүрэн/-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Г.Ганчимэг/-д үүрэг болгосугай.

САЙД



Г.ШИЙЛЭГДАМБА

D:\barimt\tushaal

080266

Эрүүл мэнд, спортын сайдын  
2015 оны 02 сарын 27 өдрийн  
78 дугаар тушаалын 1 дүгээр  
хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН ТУСГАЙ ХОГ ХАЯГДЛЫГ  
ЦУГЛУУЛАХ, ТЭЭВЭРЛЭХ, АЮУЛГҮЙ БОЛГОХ, УСТГАХ АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭ,  
ХАЛДВАРГҮЙЖҮҮЛЭЛТЭНД ДОТООДЫН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ,  
ҮНЭЛГЭЭ ХИЙХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН


Ажлын хэсгийн дарга:	Э.Оюунсүрэн, Хяналт-Шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газрын дарга
Нарийн бичгийн дарга:	Н.Цогзолмаа, Эрүүл мэндийн байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний бодлого зохицуулалт хариуцсан мэргэжилтэн
Санхүүгийн ажлын дэд хэсгийн ахлагч:	Б.Чулуунбат, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын салбарын санхүүгийн хяналт шалгалт асуудал хариуцсан улсын ахлах байцаагч
Гишүүд:	Г.Базархүрэл, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын хөрөнгө оруулалтын аудит хариуцсан мэргэжилтэн Ж.Амаржаргал, салбарын сайдын багцын төсвийн ерөнхий нягтлан бодогч
Хууль, эрх зүйн дэд ажлын хэсгийн ахлагч:	Ш.Мөнгөнцэцэг, Төрийн захиргааны удирдлагын газрын хууль эрх зүй хариуцсан мэргэжилтэн
Үйл ажиллагааны ажлын дэд хэсгийн ахлагч:	Н.Цогзолмаа, Эрүүл мэндийн байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний бодлого зохицуулалт хариуцсан мэргэжилтэн
Гишүүд:	Ц.Хандармаа, химийн бодисын аюулгүй байдлын бодлогын хэрэгжилтийн зохицуулалт хариуцсан мэргэжилтэн

Ш.Уранцэцэг, Орчны эрүүл мэндийн бодлогын  
хэрэгжилтийн зохицуулалт хариуцсан  
мэргэжилтэн

А.Мөнхжаргал, ЭМСХХ-5 төслийн дотоодын  
зөвлөх

С.Аригуун, УБ хотын захирагчийн ажлын алба,  
тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтэсд  
мэргэжилтэн

Д.Баярболд, Мэргэжлийн хяналтын ерөнхий  
газрын Эрүүл мэнд боловсрол, соёл шинжлэх  
ухааны хяналтын газрын Эрүүл мэнд,  
боловсролын хяналтын хэлтсийн дарга



Эрүүл мэнд, спортын сайдын  
2015 оны 02 сарын 27 өдрийн  
78 дугаар тушаалын 2 дугаар  
хавсралт

**ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН ТУСГАЙ ХОГ ХАЯГДЛЫГ ЦУГЛУУЛАХ,  
ТЭЭВЭРЛЭХ, АЮУЛГҮЙ БОЛГОХ, ХАЛДВАРГҮЙЖҮҮЛЭХ, УСТГАХ АЖИЛ  
ҮЙЛЧИЛГЭЭ, ХАЛДВАРГҮЙЖҮҮЛЭЛТЭНД ДОТООДЫН ХЯНАЛТ,  
ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙХ УДИРДАМЖ**

**Нэг. Үндэслэл:**

Монгол Улсын “Хог хаягдлын тухай хууль”-ийн 7 дугаар зүйлийн 7.3 дах заалт, Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 129 дүгээр тогтоолоор батлагдсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 3 дугаар зүйлийн 3.1.9 дах заалтыг, ЭМСЯ-ны удирдлагын зөвлөлийн 2015 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн хурлын шийдвэрийг үндэслэл болгоно.

**Хоёр. Зорилго:**

Эрүүл мэндийн байгууллагын тусгай хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, аюулгүй болгох, халдваргүйжүүлэх, устгах ажил үйлчилгээ, халдваргүйжүүлэлтэнд дотоодын хяналт, шинжилгээ, үнэлгээ хийж үнэлэлт дүгнэлт өгч, удирдлагыг мэдээлэлээр хангахад оршино.

**Гурав. Үйл ажиллагааны чиглэл:**


1. Эрүүл мэндийн байгууллагын тусгай хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, аюулгүй болгох, устгах ажил үйлчилгээ, халдваргүйжүүлэлтийн санхүүгийн үйл ажиллагаанд дотоодын хяналт-шинжилгээ, үнэлгээ, хийх /Төсвийн хөрөнгө оруулалтын ашиглалт, зарцуулалт, түрээсийн төлбөрийн тооцоо, өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, зарцуулалт.../
2. Эрүүл мэндийн байгууллагын тусгай хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, аюулгүй болгох, устгах ажил үйлчилгээ, халдваргүйжүүлэлтийн үйл ажиллагааны хууль, эрх зүйн орчинд үнэлгээ хийх /хууль тогтоомж, тушаал шийдвэр, гэрээ, тайлан.../
3. Эрүүл мэндийн байгууллагын тусгай хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, аюулгүй болгох, халдваргүйжүүлэх, устгах ажил үйлчилгээ, халдваргүйжүүлэлтийн үйл ажиллагаанд үнэлгээ хийх
4. Дэд ажлын хэсгийн дарга нар нь үнэлгээний тайлан зөвлөмжийг нэгтгэн, ажлын хэсгийн нарийн бичгийн даргад өгч, нэгдсэн зөвлөмж, дүгнэлт гаргах
5. Дэд ажлын хэсэг бүр хийх ажлын төлөвлөгөө боловсруулж, үнэлгээг хийх

**Дөрөв. Хамрах хүрээ:**

- Эрүүл мэндийн байгууллагын тусгай хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, аюулгүй болгох, устгах ажил үйлчилгээ, халдваргүйжүүлэх үйл ажиллагаа хамрагдана.

**Тав: Хугацаа:**

2015 оны нэгдүгээр улиралд багтаан хяналт шалгалтыг хийнэ.



**Зургаа. Хүрэх үр дүн:**

1. Эрүүл мэндийн байгууллагын тусгай хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, аюулгүй болгох, халдваргүйжүүлэх, устгах ажил үйлчилгээ, халдваргүйжүүлэлтэнд дотоодын хяналт, шинжилгээ, үнэлгээ хийж дүгнэлт, зөвлөмж гаргана.
2. Удирдлагын зөвлөлийн хурлаар танилцуулна.
3. Цаашид дүгнэлтийг үндэслээд авах арга хэмжээ болон шийдвэрүүд гаргана.